# ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛДВЭРИЙН ХӨДӨЛМӨРӨӨР ЯЛТНЫ ХҮМҮҮЖЛИЙН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

**Г. НАРАНБАЯР**

Удирдлагын Академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн профессорын багийн дэд профессор, докторант, хошууч

**Хураангуй:** Энэхүү өгүүлэлд хорих ял эдэлж байгаа этгээдийг нийгэмшүүлэх ажлын хүрээнд хорих байгууллагын үйлдвэрлэлийг манай улсад болон гадаад улс оронд хэрхэн удирдан зохион байгуулж буй, түүнчлэн хорих ял эдэлж дууссаны дараа тухайн хүнийг нийгэмших, гэмт хэргийн ертөнцөд дахин хөл тавихгүй байлгах боломжийг бүрдүүлэх талаар хувь судлаачийн байр суурийг танилцуулна.

**Abstract:** This article presents the individual researcher views on the management of prison production in Mongolia and abroad the socialization of convicts on the possibility of rehabilitation into society and reintegration after serving a sentence.

**Түлхүүр үг:** хорих анги, үйлдвэрлэл, дахин нийгэмшүүлэх, сургалт, хөдөлмөр
**Keywords:** prison, industry, rehabilitation, training and labor

## Оршил

Хүний нийгмийн хөгжил бүхий л түвшиндээ хүн төрөлхтний түүхийн аль ч үед байгаагүйгээр дэвшин хөгжиж буй ч хүмүүний ухамсараас гэмт хэрэг үйлдэх сэтгэлгээ арилаагүй төдийгүй хүний мөс чанарт өөрчлөлт тод илрэхгүй байна. Гэмт хэрэг үйлдсэн хүний тоо улс бүрт харилцан адилгүй ч үйлдлийн тоо буурсан үзүүлэлт гарахгүй байгаа явдал хоригдлыг хүмүүжүүлэх үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах шаардлагатайг илтгэж байна.

Хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх явдал ардчилалын чухал үнэт зүйл. Үүнтэй хөл нийлүүлж, хүний эрхийн олон асуудал хорих ял эдэлж байгаа этгээдэд мөн адил шаардагдаж байна. Эрхээ хасуулсан хүний “хүний эрх”-ийн асуудал гэдгийг хэрхэн ойлгох нэн ярвигтай ч эдгээр хүмүүсийг дахин гэмт хэрэг үйлдэж хорих ангид эргэн ирүүлэхгүйн тулд эргэн нийгэмшүүлэх /rehabilitation/ явдал тун чухал болно.

Эргэн нийгэмшүүлэхийн тулд эдгээр иргэдийг нийгмийн харилцаанд оролцох, хамт олны уур амьсгалд төлөвшүүлэх зэрэгт анхаарсан туршлагыг судлах зайлшгүй шаардлагатай байна.

Энэхүү өгүүлэлд хорих ял эдэлж байгаа этгээдийг нийгэмшүүлэх ажлын хүрээнд хорих байгууллагын үйлдвэрлэлийг манай улсад болон гадаад улс оронд хэрхэн удирдан зохион байгуулж буй, түүнчлэн хорих ялаа эдэлж дууссаны дараа тухайн хүнийг нийгэмших, гэмт хэргийн ертөнцөд дахин хөл тавихгүй байлгах боломжийг бүрдүүлэх талаар хувь судлаачийн байр суурийг танилцуулна.

Өөрөөр хэлбэл хорих байгууллагын үйлдвэрийн шинэ технологийг тоног төхөөрөмж, суурь машин, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи бус харин энэхүү үйлдвэрлэлээр дамжуулж хоригдлуудыг нийгэмшүүлэх ямар арга, технологи нэвтрүүлэх боломжийн талаар өгүүлэх болно.

Эрдэм шинжилгээний арга зүйн үндэслэл болгож статистик дүн мэдээ нэгтгэх, харьцуулах аргыг ашиглалаа.

Нэг. Монгол Улсын хорих байгууллагын үйлдвэрлэлийн өнөөгийн байдал

Засгийн газрын 19 дүгээр бага хурал болон Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 55 дугаар хурлаар[42] “Аливаа хэрэгтэн ялтнаар ажил, үйлдвэр хийлгэх тухай” дүрмийг 29 зүйлтэйгээр хэлэлцэн баталсан байдаг. Хоригдогсдоор ажил хийлгэх явдал хоригдол хүмүүсийг сурган боловсруулах ба засаж сайжруулах, ажлын дадлага олгох асуудлыг албадан хийлгэж, цаашид үнэнч шударга иргэн болж, ажил хийж амьдрахад сургаж, хүмүүжилтэй иргэн болгох зорилт тавьсан байна. Энэ дүрэм батлагдсан явдал хэрэгтэн ялтны хөдөлмөрийг улсын үйлдвэрлэлтэй хууль ёсоор холбож бататгасан анхны томоохон

[42] 1929 оны 06 дугаар сарын 14-ны өдөр

арга хэмжээний нэг юм. Тухайн үед хоригдол, ялтны ажил хөдөлмөрт хандах сонирхлыг дээшлүүлж, ялангуяа тэдэнд ажлын хоног олгох болсон явдал цаг үеээ олсон чухал зүйл байв. Тухайлбал хоригдлын ажлын өдрийг 8 цагаар тогтоож, 18 нас хүртэлх болон газар дор, онц хүчир, хортой ажил хийгчдийг 6 цагаас хэтрүүлэхгүй ажиллуулж, жирэмсэн эмэгтэйгээр ажил үйлдвэр хийлгэхгүй, бусад эмэгтэйчүүдээр хүнд ажил хийлгэхгүй байх, сургаж хүмүүжүүлэх ажлыг тэдний гүйцэтгэж байгаа ажлын шинж, төрөлд тохируулан явуулж, тэнд ажиллах хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалах талаар онцгой анхаарч байжээ. Хоригдлыг хөдөлмөрөөр хүмүүжүүлэх, эргэн нийгэмшүүлэх ажил дээрх цаг үеэс хэрэгжиж эхэлжээ.

Өнөөгийн байдлаар Монгол Улсын нийт 21 хорих ангид 3000 орчим хоригдол ял эдэлж байгаагаас 12 хорих ангид үйлдвэрлэлийн 19 чиглэлээр 554 хоригдол ажиллаж байна. Нийт хоригдлын 16,6 хувь нь хорихын үйлдвэрлэлд хөдөлмөр эрхэлж байна.

**Хорих анги, байгууллагын үйлдвэрлэл**

| № | Хорих анги | Үйлдвэрлэлийн чиглэл | Тоног төхөөрөмж | Хоригдлын тоо | Хоригдлуудыг хэрхэн сургадаг |
|---|---|---|---|---|---|
| 1 | 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги | Оёдлын үйлдвэр | Шулуун оёдлын машин, тусгай зориулалтын машин, уурын индүү | 80 | Үйлдвэрийн мастер 7 хоногийн хугацаанд сургалт явуулдаг |
| 2 | 409 дүгээр хаалттай хорих анги | Кашмерийн үйлдвэр, ноос, ноосон эдлэл | Оёдлын машин | 33 | МСҮТ-д болон дагалдуулж сургадаг |
| | | Мебель тавилгын үйлдвэр | Төхөөрөмж, цахилгаан хөрөө, наагч машин | 2 | Удаан ажилласан хоригдлуудыг дагалдуулж сургадаг |
| | | Зөөлөн эдлэлийн үйлдвэр | Оёдлын машин | 78 | МСҮТ-н сургалт болон дагалдуулж сургадаг |
| | | "Газар ивээл" ТӨХК-ийн гутлын үйлдвэр | Сүлжигч машин, оёдлын машин, зэрэг 50 нэр төрлийн төхөөрөмж ашигладаг | 60 | Дагалдуулж сургадаг |
| 3 | 413 дугаар нээлттэй, хаалттай хорих анги | Оёдлын үйлдвэр | Оёдлын машин, эсгүүрийн машин, утас тасдагч хайч | 22 | Дагалдуулж сургадаг |
| 4 | 415 дугаар хаалттай хорих анги | Модон эдлэлийн үйлдвэр | Токарын машин, суурин дугуй хөрөө, жижиг цахилгаан багажнууд | 28 | Дагалдуулж сургадаг |
| | | Мужаан цех | Сууpь хөрөө, градус хөрөө, цахилгаан харуул, сийлбэр хутга, ухагч хутга, гар дрилль, гар хөрөө, фризер машин, тасдагч, сүх | 14 | Ур чадвараар илүү хоригдол сургагч багш хийдэг |
| | | Токарь | Машин, алх, отверка, тасдагч, гар тасдагч, матагч | 8 | "Номин гоёл" ХХК-иас багш ирж сургадаг. |
| | | Чулууны үйлдвэр | Чулуу өнгөлөгч машин, там өрөм, жижиг өрөм, төмөр дөш, хэв дарагч, | 24 | Ур чадвараар илүү хоригдол сургагч багш хийдэг |
| 6 | 421 дүгээр нээлттэй хорих анги | Гал тогооны тоног, төхөөрөмжийн "Чиглэл" ХК/гэрээт/ | Ган төмөр зүсэгч, жижиг багажууд | 28 | Үйлдвэрийн дарга нь сургадаг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | 423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги | Мужааны цех | Суурин цахилгаан хөрөө, гар багаж | 18 | Сургалт зохион байгуулдаг |
| 8 | 427 дугаар нээлттэй, хаалттай хорих анги | Оёдлын үйлдвэр | Оёдлын машин | 23 | Дагалдуулж сургадаг |
| | | "Багануур тоосго" ТӨААТҮГ-т тоосго, блок үйлдвэр | Зориулалтын тоног төхөөрөмжтэй | 55 | "Багануур тоосго" ТӨААТҮГ-т сургалтад хамруулдаг |
| 9 | 435 дугаар хаалттай хорих анги | Оёдлын цех, гар урлал | Хөвөрлөгөөний машин, шулуун оёдлын машин, эсгүүрийн дарагч машин | 38 | |
| | | Гар урлал | Нэхий элдэх машин, зүлгэх машин | 10 | |
| 10 | 439 дүгээр хаалттай хорин анги | Сийлбэр, мужаан, чулуун сувинер, Монгол гутал, Дархан чулуун эдлэл | | 24 | Хөдөлмөрийн дадал, чадвар эзэмшүүлэх дугуйлан ажиллуулдаг |
| 11 | 441 дүгээр нээлттэй хорих анги | Төмрийн цех | | 4 | Дагалдуулж сургадаг |
| 12 | 445 дугаар нээлттэй хорих анги | Сур, суран эдлэл болон мебель тавилга угсрах, эсгий үйлдвэрлэл, баримал, мужаан сийлбэр | Оёдлын машин, эсгийн үйлдвэрлэлийн тоног, төхөөрөмж, мебель тавилгын тоног, төхөөрөмж, мужаан хөрөө, харуул | 29 | Дагалдуулж сургадаг |
| нийт | | 19 | | 554 | |

*Эх сурвалж. Хорих ял эдлүүлэх албаны мэдээллийн сан*

Хорих байгууллага нь мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон хорих ангид мэргэшүүлэх, дадлагажуулах сургалтыг зохион байгуулж буй үйл явцыг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх ач холбогдолтой гэж үздэг.

Хоёр. Гадаад улс орны шоронгийн үйлдвэрлэл, өнөөгийн байдал

Хоригдлын хөдөлмөрийг дэлхий даяар идэвхтэй ашиглаж байна. Ялтнууд цэргийн хувцас оёж, цахилгаан бараа, тавилга угсарч, улс орны төсөвт төдийгүй хувийн компаниудад ашиг авчирч байна.

Хоригдлын хөдөлмөр Орос Улсад жил бүр тэрбум рублийн ашиг авчирдаг бол тус улс ялтнуудад Европоос арав дахин бага мөнгө зарцуулдаг аж. Тус улсын эрх баригчид хоригдлуудыг мега төслийн бүтээн байгуулалтад дээр ажиллуулах талаар хэлэлцэж байна[43].

Хуулийн дагуу хоригдлуудыг ял эдэлж буй байгууллагын нутаг дэвсгэрт болон түүний гаднах ажилд татан оролцуулж болох боловч тусгаарлах, хамгаалалтад авах шаардлагатай байдаг. ОХУ-д магадлангаар суллах хүсэлтийг авч үзэхдээ сайн дурын хөдөлмөрийг харгалзан үздэг тул ялтнууд хөдөлмөр эрхлэх сонирхолтой байдаг.

ОХУ-ын хүний эрхийг хамгаалах төрийн бус байгууллагууд эрх баригчид бүтээн байгуулалтад тодорхой ангиллын ялтнуудыг татан оролцуулж болох ч зөвхөн гэрээгээр, цалин өгч оролцуулахыг шаарддаг. Учир нь иргэдийн дунд хоригдлуудыг нийгэмшүүлэхэд

[43] Бизнес в клеточку. Труд заключенных — прибыльное дело. Сколько зарабатывает на колониях Россия? https://lenta.ru/articles/2021/05/02/zakluchrabota/

зориулах хөрөнгийг зүгээр л шамшигдуулдаг гэх үзэл элбэг байдаг.

ОХУ-ын бүтээн байгуулалтад хоригдлуудын оруулсан түүхэн хувь нэмэр асар их. Гэмт хэрэгтнүүдийн хөдөлмөрийг ашиглах санаа бүр XVII зуунд дэлгэрсэн бөгөөд хатуу шийтгэл хүлээсэн хүмүүс Октябрийн хувьсгал хүртэл Сибирь, Алс Дорнодын суурьшил, хөгжилд оролцож байсан. Оросын эзэнт гүрний үед ялтнуудын хөдөлмөрийг төмөр замд (Транссибирь, Амур, Уссурийн төмөр замд) ашигладаг байжээ. Тухайлбал, Байгаль-Амурын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн лагерь (БАМлаг) 1932 онд байгуулагдаж, БАМ-ыг барих, Транссибирийн төмөр замын хоёрдугаар замыг тавих, мод бэлтгэх, боловсруулах, алт олборлох үйлдвэрлэл явуулах болсон байдаг. БАМлаг-аар хоёр сая орчим хүн дамжин өнгөрчээ. БАМлаг-ыг татан буулгаж, 1938 онд Дотоод явдлын төв хороо түүнийг Алс Дорнод дахь төмөр замын барилгын хэлтэс болгож өөрчлөн байгуулж, БАМ-ыг Транссибирийн төмөр замын шугамтай холбосон 190 км урт БАМ-Тында хэсгийг бариулсан байна[44].

Гэхдээ хоригдлуудын хөдөлмөрөөр барьсан мега төслүүд асар их хүний амь насыг хохироосон. Олон мянган хоригдлууд хоол тэжээлийн дутагдал, хүнд хэцүү амьдрал, хөдөлмөрийн нөхцлөөс болж нас барсан тухай мэдээ бий. Албан ёсны статистик мэдээгээр 1.6 сая хүн нас барсан гэж бүртгэгджээ.

Эдүгээ Холбооны хорих алба 323 хорих анги, янз бүрийн дэглэмтэй, хорих нөхцөлтэй 874 колони ажиллаж байна. Холбооны хорих алба түүнчлэн олон зуун сүм хийд, сургууль, гахайн байр, хүнсний ногооны хүлэмж, загас агнуурын аж ахуйн нэгж, барилгын компани, консерв, тос боловсруулах үйлдвэртэй байна.

ОХУ Европын хамгийн том шоронгийн төсөвтэй буюу 4.2 тэрбум евро (2020 оны эхэн үеийн байдлаар) захиран зарцуулдаг. Түүний араас Их Британи (4 тэрбум евро), Герман (3,5 тэрбум евро), Итали, Франц (2,9 тэрбум евро) ордог. Үүнийг нэг хоригдлын хоногийн дундаж зардалд хувааж үзвэл 64.4 евро байдаг аж. Гэтэл Орост хамгийн хямд буюу өдөрт нэг хоригдолд 2.8 евро зарцуулдаг бол Швед, Норвегид 300 орчим евро байдаг байна. Шоронгийн хөдөлмөрийг ашиглах явдал зөвхөн Оросын практик биш.

ХБНГУ-ын 100 мянган хүнд 80 орчим хоригдол ногдож байна. Энэ үзүүлэлтээр тус улс дэлхийн статистикийн сүүл хэсэгт оржээ. Германы хорих ангиудад албадан хөдөлмөрийн алба байдаггүй ч ажил хөдөлмөр эрхлүүлэх явдал хоригдлуудыг нийгэмшүүлэх салшгүй хэсэг гэж үздэг. Холбооны 16 муж улсын 12-т нь хуулийн дагуу хөдөлмөр эрхлэх боломжтой байдаг. Германд ял эдэлж буй хүмүүс оёдол зэрэг туслах хөдөлмөр эрхэлдэг бөгөөд хорих ангиудад гар хийцийн гэр ахуйн хэрэгсэл үйлдвэрлэдэг жижиг цехүүд байдаг. Ажлын долоо хоногт дунджаар 37 цаг үргэлжилдэг бөгөөд ялтан сард 9-250 еврогийн орлого олох боломжтой. Зарим хорих ангид дэлгүүр байдаг. Жишээлбэл, Берлинд та тавилга, хувцас, нарийн боов худалдаж авах боломжтой[45].

Харин Францад шоронгууд ачаалал ихтэй байдаг. 2021 онд тус улсын 188 хорих ангид 60,583 хорих камер, 62,673 хоригдолтой байна. Тэд хорих ангид засвар үйлчилгээ хийх эсвэл хорих анги, хувийн аж ахуйн нэгжийн хэрэгцээнд зориулж үйлдвэрт ажиллах боломжтой. Хуулийн дагуу хоригдлын цалин түр ажилтны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 20-45 хувь (цагт 4-6 евро) байх ёстой. Хувийн компаниуд хорих ангитай хамтран ажиллахаа сурталчлахгүй байхыг илүүд үздэг. Учир нь ялтнууд томоохон бренд үйлдвэрт ажиллах нь бий. Тухайлбал, Bic брэндийн бариул, сахлын машин угсрах ажилд оролцож байсан явдал ил болсны зэрэгцээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр EADS, Yves Rocher, L'Oreal компанид хоригдол ажилладаг тухай дэлгэсэн байдаг. Гэхдээ ийм хамтын ажиллагааны санхүүгийн үр дүнг зарлаагүй байна[46].

АНУ хоригдлуудынхаа тоогоор дэлхийд тэргүүлэгч хэвээр байна. Эдүгээ Америкийн шоронд хоёр сая гаруй хүн хоригдож байгаа явдал дэлхийн нийт шоронгийн хоригдлын 25 орчим хувийг эзэлдэг. Америкийн хоригдлуудын ихэнх нь арьс өнгөний хувьд

[44]БАМЛаг как один из островов ГУЛага: возникновение, история участие в Великой Отечественной войне. https://elar.urfu.ru/bitstream/10995/30810/1/Mamyachenkov_Perm_2015.pd

[45] Made in Germany'- Wer von der Arbeit in Gefangnissen profitiert. https://correctiv.org/aktuelles/justiz-polizei/leben-im-gefaengnis/2021/07/21/made-in-germany-wer-von-der-arbeit-in-gefaengnissen-profitiert/

[46] Comment les dWenus retrouvent le chemin du travail en prison. https ://www.ouest-france.fr/societe/prison/pourquoi-les-detenus-travaillent-moins-qu-avant-en-prison-6efbc970-4915-11ec-a0b7-64a183ad6699

цөөнхийн төлөөлөгчид байдаг[47].

АНУ-ын Үндсэн хуулийн 13 дахь нэмэлт, өөрчлөлтөөр шоронгийн хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрдөг болсон. Холбооны шоронгийн хоригдлууд төрийн өмчит UNICOR корпорацид ажилладаг. Түүний бүх бүтээгдэхүүн төрийн байгууллагуудад, тэр дундаа Батлан хамгаалах яаманд нийлүүлэгддэг. UNICOR шоронгуудад түшиглэн 80 орчим төрлийн бүтээгдэхүүн (хувцас, электрон бараа) үйлдвэрлэдэг олон арван үйлдвэртэй. Тэд цагт 0.23-1.15 ам.долларын цалин авдаг. Тус корпораци санхүүгийн үр дүнгээ мөн адил ил гаргадаггүй[48].

АНУ-д мөн хувийн шорон байдаг. 1980-аад онд хоригдлуудын тоо хэт нэмэгдсэний улмаас хувийн шорон үүссэн бөгөөд одоо ийм хорих ангид нийт ялтнуудын 8 хувь буюу 160 мянга орчим хүн хоригдож байна. Хувийн хорих ангиуд томоохон компаниудтай гэрээ байгуулж, тэдний хэрэгцээнд зориулж үйлдвэрлэл явуулдаг. Тухайлбал, Motorola, Compaq, Honeywell, Microsoft, Boeing, Revlon, IBM, Hewlett-Packard зэрэг бараг бүхий л том компани шоронгийн хөдөлмөрийг ашигласан байдаг.

Түүнчлэн ялтнуудыг 2019 онд ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Майкл Блүүмберг сонгуулийнхаа компанит ажилд ашигласан байдаг. Түүний төв штабын дуудлагын төвүүд хоёр хорих ангиудын үндсэн дээр байгуулагдсан операторын нэгжтэй байжээ. Хоригдлууд тэрбумтны төлөөлөгчдийн өмнөөс боломжит сонгогчдыг дуудсан гэдэг[49].

Гэвч хувийн томоохон аж ахуйн нэгжид удаан хугацаагаар хоригдох ялтай этгээд нэн ашигтай аж. Тиймээс тэд шүүхийн шийдвэрт нөлөөлөх ажиллагаа зохион байгуулсан түүхтэй. Тухайлбал, хоёр шүүгч шоронгийн компаниудаас авлига авч, өсвөр насныханд хүнд ял оноож, "Kids For Cash" (Хүүхдүүд мөнгөний төлөө хүүхэд ашиглах) хэрэг гарсан явдал үүний тод жишээ юм[50].

Хувийн шоронгууд ч хоригдлуудын хөдөлмөрийг боолын хөдөлмөр болгож ашиглаж, түүгээрээ дамжуулан өөрсдийгөө баяжуулдаг гэх шүүмж бий. 2019 оны мэдээллээс харахад салбарын тэргүүлэгчид болох GEO Group болон CoreCivic хувийн шоронгийн орлого 2.49 ба 1.9 тэрбум ам.доллар байсан бөгөөд компаниуд холбогдох мэдээллийг дэлгэрэнгүй нийтлээгүй байна. Хоёр хорих байгууллагын хамгийн том үйлчлүүлэгч АНУ-ын Цагаачлал, Гаалийн алба байсан бөгөөд 2019 онд 1.3 тэрбум ам.долларын гэрээ байгуулжээ[51].

Хоёр компани хоёулаа хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй бөгөөд дунд болон жижиг хөрөнгө оруулалттай Америкийн компаниудыг нэгтгэдэг S&P индекст багтдаг. Тэд Moody's болон S&P-ээс тун муу үнэлгээтэй байдаг явдал тэдний орлого засгийн газрын бодлогын өөрчлөлтөд маш мэдрэмтгий байдагтай холбоотой. Үнэт цаасны биржүүд CoreCivic болон GEO группын хувьцааг "нүглийн хувьцаа" (Sin stocks) гэж нэрлэдэг байна.

Нэгдсэн улсын Ерөнхийлөгч Жо Байден 2021 оны эхээр арьс өнгөний тэгш бус байдлын эсрэг тэмцлийн хүрээнд Хууль зүйн яамыг хувийн шоронтой байгуулсан гэрээгээ шинэчлэхийг албан ёсоор хориглосон байдаг. Зах зээлийн аваргуудын хувьцаа сүүлийн арван жилийн доод хэмжээнд хүртэл унасан бөгөөд компаниуд өөрсдөө энэ жил орлогынхоо дөрөвний нэгийг буюу нийтдээ тэрбум орчим ам.доллараа алдах эрсдэлтэй байгаа аж[52].

БНХАУ-ын тухайд тус улсын Жиси засан хүмүүжүүлэх колони (Зүүн хойд Хятад, Хэйлунжан муж) дахь хоригдлууд өдрийн цагаар карьер дээр ажилладаг бол шөнө нь

[47] Capitalizing on Mass Incarceration: U.S. Growth in Private Prisons. https://www.sentencingproject.org/publications/capitalizing-on-mass-incarceration-u-s-growth-in-private-prisons/

[48] Federal prison undustries. https://www.unicor.gov/publications/reports/FY2019_AnnualMgmtReport.pdf

[49]Michael Bloomberg presidential campaign, 2020. https://ballotpedia.org/Michael Bloomberg presidential campaign,_2020

[50] LUZERNE "KIDS FOR CASH" SCANDAL, https://jlc.org/luzerne-kids-cash-scandal

[51]The world’s largest private prison corporation. Owns and manages over 100 correctional, detention, and other residential reentry facilities. Provides the government with other services as part of the criminal punishment system, https://investigate.afsc.org/company/corecivic.

[52] Biden's order terminates federal private prison contracts. Here's what that means. https://www.nbcnews.com/news/nbcblk/biden-s-order-terminates-federal-private-prison-contracts-here-s-n1255776

хамгаалагчид тэднийг “World of Warcraft" тоглохыг албадаж, виртуал мөнгө олдог байна. Уг тоглоомонд 300 орчим хоригдол оролцож, өдөрт 6000 юань хүртэлх орлого олдог байжээ. Тус колонийн ялтнууд модон савх, шүдний чигчлүүр үйлдвэрлэхийн зэрэгцээ сандлын бүрээс оёж, Өмнөд Солонгос, Япон руу экспортолдог байна[53].

Дэлхийгээс бараг хаалттай Хойд Солонгос улсын ялтнуудын нөхцөл байдлын талаар мэдээлэл бага байна. Өмнөд Солонгосын хүний эрхийн төлөө тэмцэгчид 2021 онд БНАСАУ-ын эрх баригчид нүүрс олборлохдоо улс төрийн хоригдлууд, тэр дундаа хүүхдийн хөдөлмөрийг ашиглаж, улмаар экспортолдог гэсэн тайлан нийтэлжээ. НҮБ-ын тооцоолсноор 200,000 орчим хүн тусгай цагдаа нарын удирддаг хуаранд хоригдож байгаа бөгөөд ихэнх нь уурхайн талбайн ойролцоо байрладаг. Хойд Солонгос 2016 оны ийм байдлаар 8 сая орчим тонн нүүрс олборлож, 2017 онд гадаад худалдаанаас 200 сая ам.долларын орлого олжээ. Золоор цар тахлын улмаас 2020 оны зунаас ийм нүүрсний экспорт түр зогссон байна[54].

**Дүгнэлт**

Дэлхийн улс орон том, жижиг эсвэл ардчилсан болон тоталитар системээс үл хамаарч ашигтай л байвал хоригдлуудын хөдөлмөрийг ашигласаар байх болно. Ялтнуудын цалин бага, хөдөлмөрийг нь тодорхойгүй хугацаагаар ашиглах боломжтой. Хоригдлууд хямд ажиллах хүчний бараг шавхагдашгүй эх үүсвэр болж байна.

Ихэнх улс орон ялтны хөдөлмөрийг хоригдлыг нийгэмшүүлэх үйлст чухал хувь нэмэртэй гэж нэрийдэх ч үүний ард эдийн засгийн асар их сонирхол нуугдаж, үйлдвэрт ажиллаж буй хоригдлуудад хүмүүжих, нийгэмших ямар ч сургалтыг зохион байгуулдаггүй байна.

Хоригдол хөдөлмөр эрхэлснээр магадланд орж, оноосон хугацаанаас өмнө суллагдах нь дахин гэмт хэргийн ертөнцөд орох үүд хаалгыг нээж болзошгүй байна.

Засан хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх үйл ажиллагааны чухал арга хэмжээ бол хорих байгууллагын үйлдвэрлэл мөн. Хорих байгууллагын үйлдвэрлэл эдийн засгийн гэхээсээ илүүтэй хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх ач холбогдлоо өмнөө тавьсан байх ёстой. Иймд ялтныг нийгэмшүүлэх сургалтыг хорихын үйлдвэрлэлд шинэ технологи болгож нэвтрүүлэх шаардлагатай байна.

Ялтны хөдөлмөрийг “боолын хөдөлмөр” болгох явдал гэмт хэрэгтнийг хүмүүжүүлэхэд ямар ч үр дүнд үзүүлэхгүй болно.

Хорихын үйлдвэрлэл гэдгийг хамт олны уур амьсгал бий болгох, шударга хөдөлмөрийн үнэ цэнийг ойлгуулах сургалтын үйл ажиллагаа гэж ойлгож, энэ чиглэлд анхаарал хандуулах явдал эдийн засгийн ашиг сонирхлоос илүү үр өгөөжтэй болохыг хорих байгуулагын үйлдвэрлэлд шинэ технологи болгож нэвтрүүлэх шаардлагатай байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Бизнес в клеточку. Труд заключенных — прибыльное дело. Сколько зарабатывает на колониях Россия? https://lenta.ru/articles/2021/05/02/zakluchrabota/

2. БАМЛаг как один из островов ГУЛага: возникновение, история участие в Великой Отечественной войне. https://elar.urfu.ru/bitstreат/10995/30810/1 /Mamyachenkov _Регт_ 2015.pdf

3. Made in Germany” - Wer von der Arbeit in Gefangnissen profitiert. https://correctiv.orq/aktuelles/iustiz-polizei/leben-im-qefaenqnis/2021/07/21/made-in-qermany-wer-von-der-arbeit-in-qefaenqnissen-profitiert/

3. Comment les ditenus retrouvent le chemin du travail en prison. https://www.ouest-france.fr/societe/prison/pourquoi-les-detenus-travaillent-moins-qu-avant-en-prison-6efbc970-4915-11 ec-a0b7-64a183ad6699

4. Capitalizing on Mass Incarceration: U.S. Growth in Private Prisons. https://www.sentencingproject.org/publications/capitalizing-on-mass-incarceration-u-s-growth-in-private-prisons/

5. Federal prison undustries. https://www.unicor.qov/publications/reports

[53]Chinese prisoners allegedly forced to play World of Warcraft, https://channeldailynews.com/news/chinese-prisoners-allegedly-forced-to-play-world-of-warcraft/6269

[54] UN Finds Torture, Forced Labor Still Rampant in North Korean Prisons. https://www.hrw.org/news/2021/02/09/un-finds-torture-forced-labor-stilkrampant-north-korean-prisons

/FY2019_AnnualMgmtReport.pdf
6. Michael Bloomberg presidential campaign, 2020. https://ballotpedia.org/Michael _Bloomberg _presidential_ campaign,_2020
7. LUZERNE "KIDS FOR CASH" SCANDAL. https://jlc.org/luzerne-kids-cash-scandal
8. The world's largest private prison corporation. Owns and manages over 100 correctional, detention, and other residential reentry facilities. Provides the government with other services as part of the criminal punishment system. https://investigate.afsc.org/company/corecivic.
9. Biden's order terminates federal private prison contracts. Here's what that means. https://www.nbcnews.com/news/nbcblk/biden-s-order-terminates-federal-private-prison-contracts-here-s-n 1255776
10. Chinese prisoners allegedly forced to play World of Warcraft. https://channeldailynews.com/news/chinese-prisoners-allegedly-forced-to-play-world-of-warcraft/6269
11. UN Finds Torture, Forced Labor Still Rampant in North Korean Prisons. https://www.hrw.org/news/2021/02/09/un-finds-torture-forced-labor-still-rampant-north-korean-prisons